

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:


Аймаг орон нутагтаа их спортыг хөгжүүлэх, тамирчдын амжилт, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор ширээний теннисний насанд хүрэгчид, хүндийн өргөлт, спорт бүжгийн залуучууд, таеквондогийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг Арвайхээр сумандаа тус тус зохион байгуулсан.

- Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонт, Спортын мастер Т.Мэргэн багшийн нэрэмжит улсын аварга шалгаруулах ширээний теннисний насанд хүрэгчдийн тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд 20 байгууллагын 23 багийн 181 тамирчин оролцсон.
- Спортын мастер П.Дуламдорж агсны нэрэмжит хүндийн өргөлтийн Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж хот, хөдөөгийн 16 байгууллагын 105 тамирчин оролцсон. Аймгийн хүндийн өргөлтийн холбооны дасгалжуулагч Б.Дэмбэрэлдорж дасгалжуулагчтай баг тамирчид 11 алт, 15 мөнгө, 14 хүрэл нийт 40 медаль хүртэж А.Дөлгөөн, Ч.Бумчин, Г.Очирбат нар жин жиндээ рекорд дээд амжилтыг шинэчлэн тогтоож Б.Лувсандамба спортын дэд мастер цолны болзол хангаж, багийн дүгнээр эрэгтэй 1 дүгээр байр, эмэгтэй 2 дугаар байр эзэлсэн
- Таеквондогийн өсвөр үе, бага насны улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 32 байгууллагын 642 тамирчид хамрагдсан. Аймгийн таеквондогийн холбооны П.Ээбум дасгалжуулагчтай баг тамирчид алт 11, мөнгө 8, хүрэл 6 нийт 25 медаль хүртэж багаараа 1 дүгээр байр эзэлж медаль, цом, өргөмжлөлөөр шагнагдсан.
- Монголын спорт бүжгийн холбооны Залуучуудын латин бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд аймаг, нийслэлийн спорт бүжгийн клубын 105 тамирчид оролцлоо.





ТИВ ДЭЛХИЙ, ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ УРАЛДААН ТЭМЦЭЭНЭЭС АВСАН МЕДАЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ



ХҮН АМЫН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖИЛ, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ТҮВШИН ТОГТООХ СОРИЛ

